



БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

#4 (25)

Сар тутмын хэвлэл

<http://www.mnier.mn>

IV сар

**ҮНДЭСНИЙ ЭРДЭМ
ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ-ЕБС
(Нүүр 1-6)**



**ҮНДЭСНИЙ ЭРДЭМ
ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ-СӨБ
(Нүүр 7-12)**



**"НЭЭЛТТЭЙ БОЛОВСРОЛ"
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ
ХУРАЛ (Нүүр 13)**



"ХАМТЫН ОРОЛЦООНД СУУРИЛСАН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН МЕНЕЖМЕНТИЙГ ХӨГЖҮҮЛЭХ НЬ" СЭДЭВТ 57 ДАХЬ ҮНДЭСНИЙ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ



БШУЯ-ны харьяа Боловсролын Судалгааны Үндэсний Хүрээлэнгээс цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль болон мэргэжлийн боловсролын багш, удирдах ажилтнуудын дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг үндэсний эрдэм шинжилгээний 57 дахь хурал 2023-2024 оны хичээлийн жилд "Хамтын оролцоонд суурилсан сургалтын байгууллагын менежментийг хөгжүүлэх нь" сэдвээр МУБИС, Математик, байгалийн ухааны сургуулийн хурлын танхимд болон БСҮХ-ийн хүрээлэнгийн цахим хуудсаар шууд дамжуулан зохион байгуулсан.



Ерөнхий боловсролын сургууль болон мэргэжлийн боловсролын багш удирдах ажилтны салбар хуралдааны шүүгчээр БСҮХ-ийн ЭНБД, Проф. С.Санжаабадам, секторын эрхлэгч, доктор У.Туяа, секторын эрхлэгч, доктор Х.Отгонбаатар, ЭША, доктор С.Цогбадрах, ЭША, докторант Б.Алтансүх нар ажиллалаа.

Энэ жилийн эрдэм шинжилгээний хурал нь өмнө жилүүдийнхээс онцлогтой нь сургуулийн өмнөх боловсролын багш, ба удирдах ажилтан, ерөнхий боловсролын сургууль болон мэргэжлийн боловсролын багш удирдах ажилтан гэсэн хоёр салбар хуралдаан болж өргөн хүрээг хамарлаа.

Сүүлийн 3 жил цахимаар зохион байгуулагдсан ба энэ жил танхимаар зохион байгуулагдсан нь багш нар, оролцогчдын зүгээс хүлээлт, сэтгэгдэл өндөртэй хурал болж өндөрлөлөө.



Ерөнхий боловсролын сургууль болон мэргэжлийн боловсролын багш удирдах ажилтны салбар хуралдаанд 21 аймгийн 21, нийслэлийн 9 нийт 30 багийн багш, удирдах ажилтан, аймгийн БШУГ-ын төлөөлөл болсон нийт 120 гаруй оролцлоо. Хурлын эхний өдөр 21 илтгэл, хоёрдахь өдөр 9 илтгэл нийт 30 илтгэл хэлэлцүүлж дараах илтгэлүүд тус тус байр эзэллээ.



Тэргүүн байр Орхон аймгийн 4 дүгээр сургууль П.Хишигжаргал, И.Нэргүй, Г.Отгонжаргал, Я.Нямаа

СУРГУУЛЬ БҮХЛЭЭРЭЭ АЖИЛЛАХ АРГА ХАНДЛАГАД ТУЛГУУРЛАСАН МЕНЕЖМЕНТ





Дэд байр Хөвсгөл аймгийн Дэлгэрмөрөн" цогцолбор сургууль Б.Гантулга, Б.Тунгалагцэцэг, Р.Цэрэн-Очир

ДОТООД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ DMTS 5P АРГАЧЛАЛААР СУРГУУЛИЙН МЕНЕЖМЕНТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ



Дэд байр Сэлэнгэ аймгийн Мандал сумын ЕБ-ын 4-р сургууль Б.Нарангэрэл, Г.Шинэжаргал, Д.Мөнхбаатар, С.Ууганбаяр, Г.Энхмаа, Э.Мөнх-Эрдэнэ, М.Баянбулаг

АЛСЫН ХАРААНД ЧИГЛЭСЭН "ҮЕИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА"-ААР ХАМТЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ НЭГЭН ШИЙДЭЛ"





III байр Төв аймаг Зуунмод сумын 5 дугаар сургууль О.Мөнхтуул,
Б.Насанжаргал

БАГИЙН ХАМТЫН ОРОЛЦОО-СУРГУУЛИЙН МЕНЕЖМЕНТЭД НӨЛӨӨЛӨХ НЬ



III байр Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 32 дугаар сургууль Ц.Байгальзаяа,
Г.Доржпагма

**СУРГАЛТЫН БҮТЭЭЛЧ ЗАГВАРЫГ АШИГЛАН СУРГУУЛИЙН
МЕНЕЖМЕНТИЙН ҮР ДҮНД НӨЛӨӨЛӨХ НЬ**





III байр Сүхбаатар аймгийн ЕБ-ын 4 дүгээр сургууль Б.Лхагвасүрэн, Э.Сэргэлэн, М.Алтансүвд, Д.Нарантуяа, С.Эрдэнэжаргал, Б.Мөнгөнчимэг, Б.Дэлгэрмаа

ХАМТЫН АЖИЛЛАГААГААР СУРГУУЛЬД СУУРИЛСАН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ НЬ"



Тусгай байр Дундговь аймгийн Мандал сургууль М.Энхбаяр, Э.Мөнхзул, Г.Тогтохжаргал, Ж.Пүрэвсүрэн, Б.Саранзаяа, Ц.Энхцэцэг, Г.Оюунгэрэл, О.Уранбаяр, Э.Болорцэцэг, Э.Нарангэрэл



ХҮҮХЭД ТӨВТЭЙ СУРГУУЛИЙН МЕНЕЖМЕНТИЙГ ДЭМЖИХЭД "БАГШИЙН МЕНЕЖМЕНТИЙН НЭГДСЭН ЗУРАГЛАЛ"-ЫГ БОЛОВСРУУЛЖ, ХЭРЭГЖҮҮЛСЭН НЬ





Тусгай байр Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн ЕБ-ын 25 дугаар сургууль С.Анхтуяа, Б.Нямсүрэн, Д.Дэлгэрмаа

ХАМТАРСАН БАГИЙН ОРОЛЦООТОЙГООР ТЭГШ ХАМРУУЛАН СУРГАХ БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ НЬ



Тусгай байр Баянгол дүүргийн Эрдмийн өргөө сургууль С.Ариунгэрэл
ЭЦЭГ ЭХИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ ЗАМААР ХҮҮХДИЙН ХҮМҮҮЖИЛ ТӨЛӨВШЛИЙГ САЙЖРУУЛАХ СУРГУУЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ЗАГВАР



Зохион байгуулагчдын зүгээс оролцогч бүх багш нарт илтгэлийн эмхтгэл болон хурлын тэмдэг, батламжийг гардуулсан ба ирэх хичээлийн жилийн илтгэлийн сэдэв **“ИНТЕГРАЦИД СУУРИЛСАН БАГШЛАХУЙ, СУРАЛЦАХУЙ”** болохыг танилцууллаа.



Сургуулийн өмнөх боловсролын багш, удирдах ажилтны салбар хуралдаанд нийслэлийн 9 илтгэл, аймаг бүрээс шалгарсан 20 илтгэл нийт 77 оролцогчийн 29 илтгэл хэлэлцүүлээ.



Сургуулийн өмнөх боловсролын багш удирдах ажилтны салбар хуралдааны шүүгчдийн ахлагчаар БСҮХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан Проф. Б.Баярцэцэг, шүүгчдээр БСҮХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор Б.Лхамцэрэн, МУБИС-ийн СӨБС-ийн багш, доктор Ш.Цэрэннадмид, Отгонтэнгэр их сургуулийн өмнөх боловсролын тэнхимийн эрхлэгч Х.Алтанхундага, БСҮХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан докторант Г.Монголхатан нар ажиллалаа.

Тус эрдэм шинжилгээний салбар хуралдаанд дараах илтгэлүүд шагналт байр эзэлж, шүүгчдийн бүрэлдэхүүн шагналыг гардууллаа.

Эрдэм шинжилгээний хурлын эхний өдөр 21 илтгэл, хоёрдахь өдөр 8 илтгэл хэлэлцүүлсэн бөгөөд хурлын төгсгөлд багш нар өөрсдийн туршлага, санал бодлоо хуваалцаж ярилцлаа.

Эрдэм шинжилгээний хурлын модератор О.Нацагдорж “Оролцогчдоос авсан санал асуулгын үр дүн”,

шүүгч Ш.Цэрэннадмид “Эрдэм шинжилгээний хуралд оролцогчдод зөвлөмж” гэсэн сэдвээр мэдээлэл хийлээ. Тус эрдэм шинжилгээний салбар хуралдаанд дараах илтгэлүүд шагналт байр эзэлж, шүүгчдийн бүрэлдэхүүн шагналыг гардууллаа.



Тэргүүн байр Ховд аймгийн 15-р цэцэрлэг эрхлэгч Б.Энхцоож, 14-р цэцэрлэгийн эрхлэгч М.Болорцэцэг

ХАМТЫН ОРОЛЦООНД ТУЛГУУРЛАН БАЙГУУЛЛАГЫН СОЁЛЫГ ТӨЛӨШҮҮЛЭХ НЬ



Дэд байр Увс аймгийн Баруунтуруун сумын хүүхдийн цэцэрлэг Эрхлэгч Х.Эрдэнэтуяа, арга зүйч Б.Хонгорзул, багш Н.Чимгээ, М.Батнавч Ү.Цээбумба

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТИЙГ ШИНЭЧИЛСЭН ТУРШИЛТ СУДАЛГААНЫ ЯВЦ, ҮР ДҮН





Дэд байр Сэлэнгэ аймгийн Мандал сумын 3-р цэцэрлэг арга зүйч Б.Наранцацрал, багш О.Эрдэнэцэцэг, Ц.Баясах, Э.Гэрэлцэцэг, Т.Мөнхсоёл
БАГШИЙН МАНЛАЙЛАЛ, ХАМТ ОЛНЫ АЖЛЫН АМЖИЛТЫН ХАМААРЛЫГ ШИНЖИЛСЭН ЗАРИМ ҮР ДҮН



III байр Дундговь аймгийн Сайнцагаан сумын Улсын тэргүүний 3-р цэцэрлэг эрхлэгч Г.Мөнхтуяа, арга зүйч Э.Энх-Эрдэнэ, багш Б.Сүнжидмаа, Б.Бямбаа
ЦЭЦЭРЛЭГИЙН ДЭМЖЛЭГИЙН БАГИЙН ГИШҮҮДИЙН ХАМТЫН ОРОЛЦООТОЙ БАЙГУУЛЛАГЫН МЕНЕЖМЕНТИЙГ ХӨГЖҮҮЛЭХ НЬ





III байр Дархан-Уул аймгийн 22-р цэцэрлэг эрхлэгч М.Уранчимэг, багш С.Уранчимэг, Б.Отгонзаяа

БАГИЙН АЖИЛЛАГАА БАЙГУУЛЛАГЫН МЕНЕЖМЕНТЭД ЭЕРГЭЭР НӨЛӨӨЛӨХ НЬ



III байр Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 326-р цэцэрлэг багш Б.Нямхүү
СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХАД КАЙЗЕН САНАЛЫН СИСТЕМИЙН АРГЫГ АШИГЛАХ НЬ





Тусгай байр Улаанбаатар хот, Баянзүрх дүүргийн 22-р цэцэрлэгийн арга зүйч Т.Баярмаа, Э.Мөнгөнтуул

ЦЭЦЭРЛЭГИЙН “ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БОДЛОГО” -ЫН ХЭРЭГЖИЛТЭД ХАМТЫН АЖИЛЛАГАА ЧУХАЛ БОЛОХ НЬ



Тусгай байр Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 9-р цэцэрлэг эрхлэгч Н.Хишигбаяр, арга зүйч С.Янжиндулам, багш Төмөрхүү

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДҮН ШИНЖИЛГЭЭНД СУУРИЛСАН ЦЭЦЭРЛЭГИЙН МЕНЕЖМЕНТИЙН ШИНЭЧЛЭЛ





Тусгай байр Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг 316-р цэцэрлэг
Л.Адъяасүрэн
**ЦАХИМД СУУРИЛСАН МЭРГЭЖЛИЙН БАГШ НАРЫН БҮЛГЭЭР
БАЙГУУЛЛАГЫН МЕНЕЖМЕНТИЙГ ХӨГЖҮҮЛЭХ НЬ**



“ЗӨВЛӨГЧ СУРАГЧ” БОЛОН “ВЕЛКОМ” ХӨТӨЛБӨР

2023-2024 оны хичээлийн жилд англи хэлний эрчимжүүлсэн “Зөвлөгч сурагч” болон “Велком” хөтөлбөр нь 13 аймаг болон нийслэлд нийт 32 сургуульд амжилттай хэрэгжиж байна. Тус хөтөлбөрийн хүрээнд хичээл сургалтын үйл ажиллагааныхаа хэсгээс зураг бичлэгийг хаалттай бүлгэмд нийтэлж туршлагаа хуваалцдаг бөгөөд хичээлийн эхний хагас жилийн байдлаар дараах сургуулиуд хамгийн идэвхтэй пост, бичлэг түгээж ажиллав.

ВЕЛКОМ ХӨТӨЛБӨР

1. Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын 1-р сургууль

Багш: Б.Энхзул

Нийт: 58 зураг, 32:23 сек-н бичлэг

2. НЕБ-ын 72-р сургууль

Багш: Б.Бадамсүрэн

Нийт: 10 зураг, 25:37 сек-н бичлэг

3. Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын ЕБС

Багш: Б.Лхамноржмаа

Нийт: 16 зураг, 21:46 сек-н бичлэг

ЗӨВЛӨГЧ СУРАГЧ ХӨТӨЛБӨР

1. Нийслэлийн 147-р сургууль

Багш: Н.Наранцэцэг Зөвлөгч сурагч: С.Хулан

Нийт: 27 зураг, 17:41 сек-н бичлэг

2. Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 1-р сургууль

Багш: Ц.Баатар

Зөвлөгч сурагч: Н.Ууганжаргал

Нийт: 22 зураг, 03:20 сек-н бичлэг

3. Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 1-р сургууль

Багш: Б.Баянтогтох

Зөвлөгч сурагч: П.Хулан

Нийт: 19 зураг, 04:48 сек-н бичлэг

Эдгээр үйл ажиллагаа нь хөтөлбөр хэрэгжүүлж буй багш нар, зөвлөгч сурагчид хэрхэн идэвхтэй сургалтын аргуудыг хэрэглэх, хичээлээ сонирхолтой байдлаар удирдан явуулахад бие биендээ тусалж дэмжих, мэдлэг мэдээлэл хуваалцах зорилготой юм.

МУИС-ийн Математикийн тэнхим болон "Нээлттэй мэдлэг боловсролын сан"- гаас анх санаачилсан "Нээлттэй боловсрол" эрдэм шинжилгээний хурал Боловсрол Шинжлэх Ухааны Яам, Монгол Улсын Их Сургууль, Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль, Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Кемницийн Технологийн Их Сургууль, Боловсролын Судалгааны Үндэсний Хүрээлэн, Боловсролын Ерөнхий Газар, "Мэдлэг" цахим сургууль хамтран ес дэх жилдээ зохион байгуулсан. Энэ эрдэм шинжилгээний хуралд БСҮХ ээс идэвхтэй оролцлоо



ИЛТГЭЛИЙН СЭДЭВ:

- **БОЛОВСРОЛЫН ЦАХИМ ШИЛЖИЛТ ДЭХ БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ҮҮРЭГ, ОРОЛЦОО**

Буяндэлгэр Б., Мөнхмагнай А., Отгонбаатар Х., Санжаабадам С., Нацагдорж О.

- **АЛБАН БУС БОЛОВСРОЛООР НАСАНД ХҮРЭГЧДИЙН МХХТ-ИЙН СУРАЛЦАХУЙГ ДЭМЖИХ НЬ**

Мөнхмагнай А., Хүрэлтогоо М., Буяндэлгэр Б., Туяа У., Лут-Очир В.

Эрдэм шинжилгээний хурал нь Боловсролын нөөц материалууд, мэдээлэл, харилцаа холбооны технологиуд (программ хангамж, техник хангамж гэх мэт), сургалтын платформуудыг боловсролд хэрэглэх онол, арга зүй, судалгааны үр дүн болон бүх түвшний сургалтад ашиглах боломж, тэргүүн туршлагыг танилцуулж, түгээн дэлгэрүүлэх зорилготой.

Хурлын зохион байгуулагчдын зүгээс Монгол Улсад нээлттэй боловсролыг хөгжүүлэх, энэ чиглэлээр мэргэшсэн судлаачдын ур чадварыг дээшлүүлэх, хамтын ажиллагааг хөгжүүлэх, дэмжих үүднээс жил бүр тогтмол зохион байгуулах зорилго тавин ажиллаж байна. Энэ удаагийн хуралд FutureLearn, Лондон Коллеж Их сургуулийн Мэдлэг Лабораторийн Дижитал Технологитой суралцах тэнхим, ЮНЕСКО-гийн дээд боловсролын инновацийн олон улсын төвийн хөтөлбөрийн мэргэжилтнүүд зочноор уригдан оролцов. Дээд боловсролын оюутнууд болон ажилтнуудыг хөгжүүлэхэд насан туршийн онлайн сургалтын үйл явцыг ашиглах: FutureLearn хэтийн төлөв, Шинэ дижитал сурган хүмүүжүүлэх арга зүй дэх багшийн хамтын ажиллагааны хувиргах хүч, ЮНЕСКО-ICNEI-ийн алсын хараа, санаачлага хэрэгжүүлдэг төслүүдийн талаар танилцуулсан.



Хурлын илтгэлүүдэд хянан магадлагаа хийж, сайжруулсан өгүүллүүдийг эмхэтгэсэн цахим хувилбарыг та бүхэнд толилуулж байна.